

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Монгол Улсын статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

1/ Бодлого, шийдвэрийн төлөвлөлт, хэрэгжилтэд статистикийн тоо мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах;

2/ Хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгах, олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжийн хөрөнгийн зохих хэсгийг хуваарилах ажлыг зохион байгуулах;

3/ Энэхүү хөтөлбөрт нийцүүлэн яам, агентлагийн захиргааны статистикийн мэдээллийг сайжруулах арга хэмжээ авах;

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Үндэсний статистикийн хороо /А.Ариунзаяа/-нд даалгасугай:

1/ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний статистикийн хорооны зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2/ Хөтөлбөрийн биелэлтийг хангаж дүнг Улсын Их Хуралд тайлагнаж байх;

3/ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн зохих хэсгийг бүрдүүлэх ажлыг олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжийн хүрээнд зохион байгуулахад идэвхтэй ажиллах;

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Д.Тэрбишдагва/-нд даалгасугай.

Гарын үсэг

Төсөл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны

... дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН
САЛБАРЫГ 2016-2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ.....	4
ХОЁР. ӨНӨӨГИЙН ХҮРСЭН ТҮВШИН, ТҮҮНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ.....	5
ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ҮНДСЭН ШАЛГУУР	12
3.1. Хөтөлбөрийг боловсруулах зарчим.....	12
3.2. Алсын хараа.....	13
3.3. Эрхэм зорилго.....	13
3.4. Зорилго.....	13
3.5. Үндсэн шалгуур.....	13
ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	15
Зорилго 1. Үндэсний статистикийн системийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх.....	15
Зорилго 2. Статистикийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн статистикийн дэд бүтцийг хөгжүүлэх	20
Зорилго 3. Статистикийн мэдээллийн менежментийг сайжруулах.....	24
Зорилго 4. Мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	27
Зорилго 5. Статистикийн чадавхийг бэхжүүлэх.....	28
Зорилго 6. Статистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох.....	30
ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ	35
ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАХ ТОГТОЛЦОО	35
ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН	36

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНДОЭЗНК	Ази, Номхон Далайн орнуудын эдийн засаг, нийгмийн комисс
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АЁС	Албан ёсны статистик
АЁСҮЗ	Албан ёсны статистикийн үндсэн зарчим
БОЭЗДС	Байгаль орчин, эдийн засгийн дансны систем
ЕЭЗК	Европын эдийн засгийн комисс
ЕЧХА	Европын Чөлөөт Худалдааны Ассоциац
МТЕС	Мэдээлэл тархаах ерөнхий систем
МТТС	Мэдээлэл тархаах тусгай стандарт
МЧҮТ	Мэдээллийн чанарын үнэлгээний тогтолцоо
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
НАХ	Нөөц, ашиглалтын хүснэгт
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБСК	Нэгдсэн үндэстний байгууллагын статистикийн комисс
ОУЦҮ	Олон улсын цогц үнэлгээ
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СБУАЕЗ	Статистикийн бизнесийн үйл ажиллагааны ерөнхий загвар
СЗ	Статистикийн зөвлөл
СХҮХ	Статистикийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
УИХ	Улсын их хурал
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ҮСС	Үндэсний статистикийн систем
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТС	Үндэсний тооцооны систем
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ХААТ	Хөдөө аж ахуйн тооллого
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын Үндэсний Статистикийн Систем (ҮСС)-ийн хөгжлийн дунд хугацааны зорилтыг бүхэлд нь томъёолж, тодорхойлсон стратегийн баримт юм.

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) нь албан ёсны статистик (АЭС)-ийн үзүүлэлтийг тооцох, тооллого, судалгаа явуулах талаар ойрын зорилтыг тодорхойлсон хөтөлбөрийг боловсруулж, УИХ-аар батлуулах"-аар заасны дагуу статистикийн салбарыг 2006-2010 болон 2011-2015 онд хөгжүүлэх хоёр удаагийн хөтөлбөрийг боловсруулж, УИХ-аар батлуулан, амжилттай хэрэгжүүлсэн.

Дэлхийн хөгжлийн нийтлэг чиг хандлагыг тодорхойлж, НҮБ-аас боловсруулан гаргаж байгаа "2015 оноос хойших" хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Статистикийн хэлтсээс гаргасан АЭС-ийн шинэчлэлийн хөтөлбөр, Үндэсний хэмжээний тогтвортой хөгжлийн бодлого, Монгол Улсын үндэсний статистикийн системд 2013-2014 онд хийсэн олон улсын цогц үнэлгээний үр дүн зэрэг нь 2016-2020 онуудад хэрэгжүүлэх гуравдахь удаагийн хөтөлбөрийг боловсруулах гол үндэслэл болж байна.

Дэлхий нийтээрээ өнгөрсөн 15 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн Мянганы хөгжлийн зорилтоо дүгнэж, 2030 он хүртэлх дараагийн томоохон зорилтоо нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, сайжруулах, байгаль орчныг хамгаалах асуудлыг бүхэлд нь хамруулан 17 зорилго, 169 зорилт, 240 гаруй үзүүлэлт бүхий "Тогтвортой хөгжлийн зорилт" болгон дэлхийн түвшинд томъёолж, НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 70 дугаар чуулганаар "Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр"-ийг баталсан бөгөөд уг хөтөлбөрт тусгасан тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг хэрэгжүүлэхэд дэлхийн улс орнууд хэрхэн хамтран ажиллах тухай тусгагдсан.

Дээрх зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдийг Монгол Улсын дунд болон урт хугацааны зорилт, бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулан оновчтой тогтоож, түүний хэрэгжилтийг хангах нь статистикийн байгууллагын хувьд чухлаар тавигдаж байна. Үүнтэй холбоотойгоор олон улсын

байгууллагуудаас зөвлөмж болгосон нийтлэг арга зүй, ангилал, стандарт, ангиллуудыг өөрийн оронд бүрэн мөрдүүлэх; мэдээллийн нэмэлт хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, бий болгох; шинэ, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх; боловсон хүчнийг сургаж бэлтгэх шаардлага гарч байгаа бөгөөд энэ бүхэн албан ёсны статистикийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдаж, хэрэгжих боломжтой.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа "Хорин нэгдүгээр зууны статистикийн хөгжлийн төлөөх түншлэл" (PARIS21) байгууллагаас 2015 онд боловсруулан гаргасан "Статистикийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр-2.0" гарын авлагыг баримтлав.

ХОЁР. ӨНӨӨГИЙН ХҮРСЭН ТҮВШИН, ТҮҮНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

2.1. Статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 23 зорилт, 160 арга хэмжээний биелэлт 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бүрэн хэрэгжсэн 156 ажил буюу 97.5 хувь, хэрэгжих шатандаа буй 3 ажил буюу 1.9 хувь, хугацаа хойшлогдсон 1 ажил байна.

Статистикийн салбарын өнөөгийн хүрсэн түвшинг хураангуйлан харуулбал:

- Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуульд заасны дагуу эрх зүйн хүрээнд Хүн ам, орон сууцны тооллогыг зохион байгуулж, Монгол Улс гадаадад суугаа хүн амаа анх удаа интернетээр тоолсон;
- Хөдөө аж ахуйн тооллогыг анх удаа зохион байгуулсан;
- Хүн ам, орон сууцны тооллого болон Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын үр дүнд газар зүйн мэдээллийн системийг анх удаа ашиглан, орон зайн мэдээллийг бий болгосон;
- Олон улсад нийтлэг мөрддөг арга зүй, аргачлал, дэлхийн улс орнуудын болон өөрийн орны өмнөх туршлагад үндэслэн Монгол Улсын ГУРВАН САЯ дахь иргэнийг тусгай хөтөлбөр, арга зүйн дагуу тодруулсан;

- Монгол Улсын “Статистикийн тухай” хуулинд заасан Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа болон Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаануудыг нэгтгэн “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа” нэртэй нэгдсэн судалгаа явуулж байхаар 2013 онд хууль эрх зүйн өөрчлөлт оруулж, судалгааг явуулсан бөгөөд судалгааны мэдээлэл цуглуулалтыг асуулгын хуудас нөхөх уламжлалт аргаар бус орчин үеийн технологийн дэвшил болох таблет ашиглан зохион байгуулсан нь ихээхэн хүн хүч, хөрөнгө, цаг хугацаа хэмнэсэн төдийгүй судалгааны мэдээллийг тухай бүр интернетээр татаж авах бололцоо бүрдүүлж, мэдээллийг чанартай, богино хугацаанд нэгтгэн гаргах боломжтой болсон;
- ҮТС 2008-д шилжих зорилт, хөтөлбөрөө тодорхойлж, ДНБ болон ҮНО-ыг тооцож, мөн данснуудын дарааллаар хөрөнгийн дансыг хүртэл эдийн засгийн сектороор боловсруулснаар нэвтрэлт (Milestone)-ийн 1 дүгээр түвшнээс 4 дүгээр түвшинд шилжих болзлыг хангасан;
- Байгаль орчин, ногоон өсөлтийг тодорхойлох үзүүлэлтийн системийг тодорхойлж, байгаль орчны анхдагч, суурь данс болох Материал урсгалын дансыг анх удаа байгуулсан;
- Олон улсад нийтлэг мөрдөж буй 6 төрлийн ангилал (Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангиллын хувилбар 4.0, Бүтээгдэхүүний нэгдсэн ангиллын хувилбар 2.0, Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний олон улсын ангилал, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын ангилал, Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан (HS) систем, Засгийн газрын үйл ажиллагааны ангилал)-ын хамгийн сүүлчийн хувилбарыг өөрийн орны онцлогт нийцүүлэн мөрдүүлсэн;
- Монгол Улсын үндэсний статистикийн салбарт “Статистик мэдээллийн сангийн менежмент, үйлчилгээний систем-МОНСИС”-ийг нэвтрүүлж, статистик мэдээллийг хэрэглэгчдэд мэдлэг болгож хүргэх боломжийг бүрдүүлсэн;

- Төрийн байгууллагуудад бий болсон мэдээллийн санг судалж, уялдуулах, ашиглах ажлыг эхлүүлж, Үндэсний дата төвд байрлах УБЕГ-ын иргэний мэдээллийн санг Хүн ам, өрхийн мэдээллийн сантай; хуулийн этгээдийн мэдээллийн санг Бизнес регистрийн мэдээллийн сантай уялдуулж, статистикийн үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн;
- Мал тооллогын мэдээллийн онлайн системийг нэвтрүүлж, баг, хорооны түвшинд мал тооллогын дүнг мэдээллийн санд шууд ачааллах, өрхийн дэлгэрэнгүй мэдээллийг гаргах боломжийг бүрдүүлсэн;
- Дэвшилтэт технологи ашиглан салбарын хэмжээний болон дэлхийн улс орнуудын хооронд видео хурал, онлайн сургалтыг зохион байгуулдаг болсон;
- Статистикийн мэдээллийг ҮСХ-ны веб хуудас болон мэдээллийн санг ашиглан тархаах замаар хэрэглэгчдийн статистикийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлж, статистикийн мэдээллийн ашиглалтыг нэмэгдүүлсэн; статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайтаас хэрэглэгч шаардлагатай мэдээллээ өөрийн хүссэн хэлбэрээр шууд авах техникийн шийдлийг бүрдүүлж, статистикийн мэдээллийг инфографикаар болон цахим хэлбэрээр хүргэхэд түлхүү анхаарч ажилласан;
- ҮСХ нь НҮБ-ын Статистикийн комиссын жинхэнэ гишүүнээр анх удаа сонгогдон ажилласан;
- "Байгалийн нөөцөд суурилсан эдийн засгийн статистик"-ийн Улаанбаатар хотын группийг санаачлан, байгуулж ажилласан;
- Европын Чөлөөт Худалдааны Ассоциац (ЕЧХА), НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК) болон НҮБ-ын Европын Эдийн засгийн комисс (НҮБ-ын ЕЭЗК) хамтран үндэсний статистикийн систем (ҮСС)-д Олон улсын цогц үнэлгээ (ОУЦҮ)-г хийсэн;
- Монстат төслийн хүрээнд статистикийн мэдээлэл хэрэглэгчдийн дунд явуулсан хөндлөнгийн судалгааны дүнгээр хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн

түвшинг арван баллын үнэлгээгээр үнэлэхэд хоёр жилийн хугацаанд 6.68-аас 7.10 болж нэмэгдсэн;

- Монгол Улсын үндэсний статистикийн чадавхи, үйл ажиллагаа эрс өсч ирснийг олон улсын бие даасан байгууллагуудын мэдээллийн эх үүсвэрүүд харуулж байна. Дэлхийн банкнаас улс орнуудын статистикийн байгууллагын чадавхийг үнэлдэг жил бүрийн үнэлгээгээр 2015 онд Монгол Улсын Үндэсний статистикийн чадавхийн ерөнхий дундаж оноо 74.4 болж, дэлхийн дунджаас 6.4 нэгжээр дээгүүр байгаа бөгөөд статистикийн аргачлалаар 60, мэдээллийн эх үүсвэрээр 100 баллын үнэлгээг тус тус авсан;

Статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрөөс Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үзүүлэлтүүдийг тооцох арга зүйг судалж нэвтрүүлэх; Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны статистикийн мэдээллийг тооцох үндэсний аргачлал боловсруулах, мөрдөх; "Ногоон ДНБ"-ий туршилт тооцоог хийх зэрэг үйл ажиллагаа хөтөлбөрийн хугацаанд хэрэгжээгүй байна.

2.2. Үндэсний статистикийн системд хийсэн үнэлгээ

Үндэсний статистикийн системийн өнөөгийн хүрсэн түвшинг үнэлэхдээ дараах арга замуудыг ашигласан. Үүнд:

- 1) Үндэсний статистикийн салбарын үйл ажиллагаанд 2013-2014 онд хийсэн **Олон улсын цогц үнэлгээ (ОУЦҮ)**;
- 2) Давуу болон сул тал, боломж, эрсдэлийг харуулсан **SWOT шинжилгээ**;
- 3) Мэдээллийн нээлттэй байдлыг үнэлдэг **ODW үнэлгээ** зэрэг болно.

2.2.1. Олон улсын цогц үнэлгээ

Монгол Улсын ҮСС-ийн институцийн бүтэц, зохион байгуулалт, түүний дотор Монгол Улсын АЁС-ийн үйл ажиллагааг олон улсын болон Европын стандарт, хэм хэмжээ, зөвлөмжийн дагуу явагдаж буй эсэхийг тодорхойлох зорилготой Олон улсын цогц үнэлгээг Европын Чөлөөт Худалдааны Ассоциац

(ЕЧХА), НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК) болон НҮБ-ын Европын Эдийн засгийн комисс (НҮБ-ын ЕЭЗК) хамтран зохион байгуулсан.

Цогц үнэлгээний тайланд МУ-ын "Статистикийн тухай" хуулийн дагуу албан ёсны статистикийг эрхлэн гаргах, зохицуулах арга механизм нь тогтворжсоныг; статистикийн үйл ажиллагаа нь эрчимтэй хөгжиж, улс орныхоо бусад салбарын хувьд тэргүүлэх байр суурийг эзэлж байгааг; ҮСХ нь олон улсын байгууллагуудаас гаргасан албан ёсны статистикийн стандарт болон шилдэг туршлагыг өөрийн үйл ажиллагаанд болон хамтрагч байгууллага/яам, агентлаг, ААНБ/-уудад оновчтой нэвтрүүлж байгааг; олон талт болон хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлснээр Монстат зэрэг хөтөлбөр төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлж салбарын чадавхийг бэхжүүлснийг онцлон тэмдэглэсэн.

ОУ-ын цогц үнэлгээний гол үр дүн:

Давуу тал:	Тулгамдаж буй асуудал:
Статистикийн талаарх хууль тогтоомж:	
<ul style="list-style-type: none"> • МУ-ын "Статистикийн тухай" хуулинд ҮСХ-ны болон АЭС-ийг үйлдвэрлэгчдийн бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан; • Мэргэжлийн хараат бус байдал, нууцлалыг хадгалах талаар НҮБ-ын үндсэн зарчмууд мөрдөгдөж байна; • Статистикийн үндсэн үзүүлэлт болон зохион байгуулах тооллого, судалгааг нэр заан тусгаж өгсөн. 	<ul style="list-style-type: none"> • НҮБ-аас баталсан албан ёсны статистикийн үндсэн зарчим яамд, агентлагууд болон орон нутгийн түвшинд бүрэн хэрэгжээгүй; • Монгол Улсын "Статистикийн тухай" хуулинд албан ёсны статистикийн чанарын удирдлагын стандартыг тусгаагүй.
Монгол Улсын ҮСС болон статистикийн байгууллага:	
<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын "Статистикийн тухай" Монгол улсын хуулинд ҮСС болон статистикийн байгууллагын бүтцийг тодорхойлж өгсөн; • ҮСХ нь системийн гол зохицуулагчийн үүргийг гүйцэтгэдэг; • Статистикийн зөвлөл нь хуулийн дагуу байгуулагдсан, ҮСХ-ны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөхийн зэрэгцээ СХҮХ-ийг боловсруулах үйл ажиллагаанд оролцдог. 	<ul style="list-style-type: none"> • ҮСС-ийн хамрах хүрээ, зохицуулалт тодорхой бус, ҮСХ-ны эрх үүргийн хамрах хүрээг хязгаарласан; • Мөн ҮСС-ийн зохицуулалтын арга хэрэгсэл тодорхой бус, тухайлбал "Статистикийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" болон Статистикийн зөвлөлийн үйл ажиллагааны талаар хуульд оновчтой тусгагдаагүй.
Статистикийн дэд бүтэц:	
<ul style="list-style-type: none"> • Монстат төслийн хүрээнд хөрөнгө оруулалт (Мэдээлэл технологийн сүлжээний аюулгүй 	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн технологийн хөгжлийн асар хурдацтай хөгжилтэй зэрэгцэх;

<p>байдлын систем) хийгдсэн;</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээллийн технологийн сүүлийн үеийн ололтуудыг мэдээлэл цуглуултад ашигласны дүнд ихээхэн хэмжээний цаг хугацаа, зардал хэмнэсэн; • Мэдээлэл боловсруулалт, мэдээллийн технологийг хөгжүүлэх урт хугацааны зорилтын хүрээнд "Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар"-ыг боловсруулсан; • Мэдээллийн технологийн ажилтнуудыг мэргэшүүлсэн. 	<ul style="list-style-type: none"> • Мэргэшсэн ажилтнуудыг тогтвор, суурьшилтай ажиллуулах, ажлын ачааллыг зөв хуваарилах, шинэ програм хангамж зохиох шаардлагыг байнга харгалзан үзэж байх; • Боловсон хүчнийг чадавхижуулах бодлогод байгууллагын болон хувь хүний хөгжлийн зорилтыг уялдуулах;
Мэдээлэл тархаалт болон хэрэглэгчдийн хамтын ажиллагаа	
<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл тархаалтын нэгдсэн хуваарьтай болж хэвшсэн; • Мэдээлэл тархаалтын ерөнхий системд нэгдсэн; • Мэдээлэл тархаах систем www.1212.mn болон "1212" лавлах утас ажиллуулж байгаа; • MonStat болон EZSTAT апплейкшн нэвтрүүлсэн; • Хэвлэмэл бүтээгдэхүүний стандарт, загвартай; • Мэдээлэл тархаах газарзүйн мэдээллийн системийг ашигласан; • Мэдээлэл тархаалтын тусгай стандартад бүртгүүлэх зорилт тавин ажиллаж байна; • Хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэж байна. 	<ul style="list-style-type: none"> • Мета мэдээллийн санг илүү сайн бүрдүүлэх; • Мэдээллийг хянаж, засварлах чиглэлээр тусгайлсан бодлого боловсруулах; • Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг сайжруулах; • Хэрэглэгчдийн хэрэгцээнд суурилсан мэдээллийг гаргах, нэгтгэх.
Олон улсын хамтын ажиллагаа	
<ul style="list-style-type: none"> • ҮСХ нь олон улсын байгууллагуудын нэр хүндтэй түнш, хамтрагч болсон; • Олон талт болон хоёр талт нээлттэй хамтын ажиллагаатай; 	<ul style="list-style-type: none"> • Олон төрлийн зөвлөх үйлчилгээ, төсөл, төлөөлөгчийн газруудын цаг хугацаа шаардсан үйл ажиллагаа нь хэрэгтэй мэдлэгийг дамжуулахад саад учруулах эрсдэлтэй.
Мэдээллийн эх үүсвэр, боловсруулалт, чанар	
<ul style="list-style-type: none"> • Чанарын баг ажиллуулж, чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлж эхэлсэн; • Ихэнхи салбарын статистикийг хөгжүүлэхэд олон улсын аргачлал, ангиллын сүүлийн хувилбаруудыг ашиглаж байна; • Эдийн засгийн бүртгэл, тооллогод ашиглаж буй үндэсний ангилал нь олон улсын стандартад нийцсэн; • Бизнес регистрийн санг байгуулсан, өөрчлөлтийг тогтмол хийж байна. 	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл цуглуулах өртөг өндөр байгааг анхаарах; • Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад хийгдэх чанарын үнэлгээг сайжруулах.

2.2.2. SWOT шинжилгээ

Давуу талууд:	Сул тал:
<ul style="list-style-type: none"> • Статистикийн систем нь улс төрийн түвшинд дэмжлэг авч байна; • Статистикийн системийн бие даасан байдалд улс төрийн нөлөө бага; • ҮСХ-ны манлайлал нь мэргэжлийн, хэрэглэгчдэд чиглэсэн, ил тод байхад чиглэсэн; • Манлайлал нь тогтвортой; • Ажиллагчдын шилжих хөдөлгөөн бага; • Техникийн туслалцаа үзүүлэх олон талт болон хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай орчин бүрдсэн. 	<ul style="list-style-type: none"> • Статистикийн системийг өргөн хүрээнд хөгжүүлэх урт хугацааны стратегийн зорилт дутмаг; • Бусадтай оролцогч талуудтай харилцах болон тэдгээрийн зохицуулалтыг дэмжих дэд бүтэц дутмаг; • ҮСС-ийн байгууллага, нэгжүүдийн хооронд үүрэг, үйл ажиллагааны хуваарилалт хангалттай бус; • ҮСС-ийн байгууллага, нэгжүүдийн мэдээлэл давхардалтай байдаг; • Дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын нөөц хязгаарлагдмал, статистикийн хөтөлбөрүүдийн санхүүжилт хангалтгүй; • Статистикийн дэд бүтэц (арга зүй, бүртгэл, ангилал) хангалтгүй хөгжсөн; • Нөөцийг илүү үр дүнтэй, үр ашигтай ашиглахад ҮСХ-ны ажлын цар хүрээ болон бүтэц зохион байгуулалт тохиромжгүй.
Боломж:	Эрсдэл:
<ul style="list-style-type: none"> • Статистикийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ҮСС-ийн байгууллага, нэгжүүдийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох боломжтой; • Баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргадаг арга барилыг засгийн газарт нэвтрүүлэх боломжтой; • Засгийн газрын хөгжлийн зорилтууд болон шинэ эрэлт хэрэгцээтэй уялдсан мэдээллийг бий болгох үйл ажиллагааны хөтөлбөрийг нэвтрүүлэх боломжтой; • Дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын нөөцийг бий болгох боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • ҮСС-ийг бүрэн хамарсан шинэчлэлийн багц хөтөлбөр хэрэгжүүлэхгүйгээр хэрэглэгчдийн хэрэгцээнд суурилсан мэдээллийг гаргах, баримтад тулгуурласан шийдвэр гаргах боломжгүй болно. • Статистикийн мэдээлэл хэрэглэгчдийн дунд найдвартай итгэлтэй байдал алдагдана. • Судалгаанд оролцогчид мэдээлэл өгөхөөс татгалзана. • Ил тод, хариуцлагатай, нээлттэй засаглалын тогтолцоог дэмжих нээлттэй мэдээллийн тогтолцоо улс орон даяар дутмаг байх болно.

2.2.3. Мэдээллийн нээлттэй байдлын үнэлгээ

Дэлхийн банкнаас “Open data Watch” үнэлгээний загварыг ашиглан статистикийн мэдээллийн нээлттэй байдалд туршилт үнэлгээг хийсэн.

Үнэлгээгээр ҮСХ-ны цахим хуудсанд байрлуулсан, нийтэд тархааж буй мэдээлэл нь хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны гэсэн 3 багцад багтах 20 салбарын мэдээллээр хязгаарлагдаж байгаа бөгөөд статистикийн мэдээллийн хамрах хүрээ нь боломжит онооны 40.0 хувь, тэдгээрийн нээлттэй байдал нь 10.0 хувьтай байна гэж дүгнэсэн. Дээрх үнэлгээний дүн нь орон нутгийн түвшинд нэгтгэгдэж буй мэдээллийн олдоц хангалтгүй, мэдээллийг цахим хуудаснаас татаж авахад төвөгтэй байсантай холбоотой.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ҮНДСЭН ШАЛГУУР

3.1. Хөтөлбөрийг боловсруулах зарчим

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг томъёолохдоо дараах үндсэн зарчмыг баримталсан. Үүнд:

- Олон улсын арга зүйд нийцсэн, нэгдмэл байдлыг хангасан, статистикийн тогтвортой хөгжлийн үндэс суурийг бүрдүүлсэн, үндэсний хөгжлийн бодлогод тусгагдсан байх;
- Хэрэгжүүлэх боломжтой, үр дүн нь тодорхой байх;
- Хэрэгжилт нь төр, засгийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллага, иргэний хариуцлага, санаачлага, оролцоонд тулгуурласан байх;
- Статистикийн салбарын шинэчлэл нь өндөр хөгжилтэй орнуудын жишгийг баримталсан байх;
- "Статистикийн систем нь хаашаа, юу хийхээр зорьж байна, үүнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ" гэсэн асуултад бүрэн хариулсан байх зэрэг болно.

3.2. Алсын хараа

Үндэсний статистикийн системийн алсын хараа нь хэрэглэгчдийн мэдээллийн байнга өөрчлөгдөж буй хэрэгцээг бүрэн хангасан, олон улсын жишигт нийцсэн, чанарын өндөр түвшинг хангасан статистикийг хөгжүүлэхэд оршино.

3.3. Эрхэм зорилго

Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн, байгууллагад адил тэгш үйлчлэхэд оршино.

3.4. Зорилго

Хөтөлбөрийн үндсэн зорилго:

Зорилго 1. Үндэсний статистикийн системийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх;

Зорилго 2. Статистикийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн статистикийн дэд бүтцийг хөгжүүлэх;

Зорилго 3. Статистикийн мэдээллийн менежментийг сайжруулах;

Зорилго 4. Мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

Зорилго 5. Статистикийн чадавхийг бэхжүүлэх;

Зорилго 6. Статистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох.

3.5. Үндсэн шалгуур

Хөтөлбөрийн үр дүнд бий болох статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дараах үндсэн шалгуур, зарчмуудыг хангасан байна. Үүнд:

1. Нэгдмэл байдлыг хангасан байх: *ойлголт, тодорхойлолт нь шинжлэх ухааны үндэслэлтэй, бүх түвшинд ижил ойлголт, тодорхойлолт ашигласан, олон улсын стандарт, арга зүйд нийцсэн байна;*

2. Нууцлалыг бүрэн хангасан байх: *статистикийн зорилгоор цуглуулсан хуулийн этгээд болон хувь хүний мэдээллийг бусдад задруулахыг хориглоно;*
3. Бие даасан байдлыг хангасан байх: *аливаа гадны нөлөөлөлд автахгүйгээр, мэргэжлийн бие даасан байх, өөрөөр хэлбэл статистикийн байгууллага улс төрийн болон сонирхлын бүлгүүд, олон нийт эсхүл үндэсний болон аливаа байгууллагын нөлөөллөөс ангид байж, статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах, ялангуяа арга төхник, тодорхойлолт, арга зүй, ашиглах эх үүсвэрээ сонгох, тархаалтын хэлбэр болон цаг хугацааг сонгож ашигласан байна;*
4. Чанарын өндөр түвшинг хангасан байх: *цаг хугацаанд нь чанартай, уялдаатай, үнэн бодит мэдээллээр хэрэглэгчдийг хангана;*
5. Харьцуулагдахуйц байх: *олон улсын болон үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, стандартыг мөрдөнө;*
6. Хариуцлага, ил тод байдлыг хангасан байх: *ашиглахад хялбар, тайлбарлаж болохуйц байх;*
7. Жендэрийн мэдрэмжтэй байх: *статистикийн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тархаах зэрэг бүх үйл ажиллагаанд жендэрийн асуудлыг хамтад нь авч үзнэ;*
8. Хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн байх: *боломжит бүх задаргаа хийгдсэн байна;*
9. Стандартчилагдсан, өөр хоорондоо уялдаа, хамааралтай байх: *арга зүйн хувьд нэгдмэл байна;*
10. Хамтын ажиллагаа, оролцоог хангасан байх: *статистикийн үйлдвэрлэгчид, мэдээлэл нийлүүлэгчид, хөгжлийн түншүүдийн хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг хангана.*

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилго 1. Үндэсний статистикийн системийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 1: Удирдлага, зохицуулалтыг хангах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

1.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.1.1 "Статистикийн тухай" хууль, бусад холбогдох эрх зүйн актуудыг олон улсын тэргүүний туршлагад үндэслэн, бие даасан байдал, албан ёсны статистикийн зарчмууд бүрэн тусгагдсан байхаар шинэчлэх;

1.1.2 "Статистикийн тухай" хууль, бусад холбогдох тогтоомжид нийцүүлэн дагалдах дүрэм, журмуудыг шинэчлэн, мөрдүүлэх;

1.2. Хүлээгдэж буй үр дүн:

1.2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль, холбогдох дүрэм, журам боловсронгуй болж, эрх зүйн орчин бүрдэнэ.

Зорилт 2: Үндэсний статистикийн системийн хүрээнд албан ёсны статистикийн мэдээллийн чанар, бодит байдал, уялдаа холбоо, шуурхай, хүртээмжтэй байдлыг сайжруулах зохицуулалтын үр нөлөөтэй хөшүүргийг бий болгоно.

2.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1.1. "Статистикийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг нотолгоонд суурилж бодлого боловсруулах, шийдвэр гаргахад чиглүүлж, үндэсний хөгжлийн бодлого, баримт бичигтэй уялдуулж хэрэгжүүлэх;

2.1.2. Статистикийн байгууллагыг хамгийн бага зардлаар өндөр бүтээмжтэй, чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх зорилгод нийцүүлж, шинэчлэн зохион байгуулах;

- 2.1.3. Хүний нөөцийн хөгжлийн үр дүнтэй, оновчтой арга, механизмуудыг хөгжүүлэх;
- 2.1.4. Статистикийн салбарын албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг явуулах, орчин үеийн шаардлагад нийцсэн зайн сургалтын орчинг бүрдүүлэх;
- 2.1.5. ҮСС-ийн байгууллага, нэгжүүдийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, солилцох, тархаах ажлын уялдааг хангаж, арга зүйг сайжруулах, боловсронгуй болгох;
- 2.1.6. Санхүүгийн нэгдсэн, оновчтой арга хэрэгслийг бий болгох;
- 2.2. *Хүлээгдэж буй үр дүн:*
 - 2.2.1. ҮСС-ийн тогтолцоог сайжруулж, бэхжүүлснээр статистикийн мэдээллийн чанар сайжирна, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нэмэгдэнэ.

Зорилт 3: Мэдээлэл тархаалтын олон улсын стандартад нийцүүлсэн тогтолцоог бүрдүүлнэ.

- 3.1. *Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:*
 - 3.1.1. Олон Улсын Валютын сангийн Мэдээлэл Тархаалтын Тусгай Стандарт (МТТС)-д шилжих;
 - 3.1.2. ҮСС-ийн хүрээнд статистикийн мэдээллийг эрхлэн гаргаж буй байгууллагуудыг холбосон, мэдээллийн сан бүхий статистикийн нэгдсэн портал байгуулж, хөгжүүлэх;
 - 3.1.3. Нээлттэй мэдээллийн стандартын дагуу хэрэглэгчдэд статистикийн мэдээллийг хүртээмжтэй, шуурхай хүргэх боломжийг бүрдүүлж, нээлттэй мэдээллийн нэгдсэн систем байгуулж, хөгжүүлэх;
 - 3.1.4. Олон улсын байгууллагуудад тархаах үндэсний мэдээллийн уялдааг хангаж, тавих хяналтыг тогтмолжуулах;

- 3.1.5. Статистикийн анхдагч мэдээлэлтэй ажиллах нэгдсэн систем байгуулж, хөгжүүлэх;
- 3.1.6. Мэдээллийг хянаж, алдааг засварлах журам баталж, мөрдөх;
- 3.1.7. Хэвлэмэл бүтээгдэхүүний нэгдсэн загвар, стандартыг боловсруулж, мөрдөх;
- 3.1.8. Хэвлэлийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хэвлэмэл бүтээгдэхүүний чанар, загвар дизайныг сайжруулан, нэр төрлийг олшруулах;
- 3.1.9. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол давтамжтайгаар зохион байгуулах;
- 3.2. *Хүлээгдэж буй үр дүн:*
 - 3.2.1. Хэрэглэгчдэд статистикийн мэдээллийг нээлттэй хэлбэрээр тогтсон графикийн дагуу тархааж хэвшсэн байна.

Зорилт 4: Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлнэ.

- 4.1. *Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:*
 - 4.1.1. Гадны орны туршлагыг судалж, хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулах;
 - 4.1.2. Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх сургалтын асуудал хариуцсан сургагч багш нарын багийг бүрдүүлэх, сургах, мэргэшүүлэх;
 - 4.1.3. Эдийн засаг, статистикийн мэргэжлийн суралцаж буй оюутнууд, статистикийн анхдагч мэдээллийг гаргагч аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын ажилтнуудад статистикийн мэдээллийн ач холбогдлыг таниулах, түүнийг ашиглах мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах;
 - 4.1.4. Батлагдан мөрдөж буй салбарын статистикийн аргачлал, арга зүйг хэрэглэгчдэд ойлгомжтой дүрст болон инфографик

хэлбэрээр бэлтгэж, онлайн мэдээллийн хэрэгсэл, ҮСХ-ын вэб сайт, фэйсбүүк, твиттерээр олон нийтэд хүргэж хэвших;

4.2. Хүлээгдэж буй үр дүн:

4.2.1. Статистикийн талаарх мэдлэг нэмэгдэж, статистикийн мэдээллийн хэрэглээ нэмэгдсэн байна.

Зорилт 5: Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

5.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1.1. Статистикийн чиглэлээр ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн төрийн ба олон улсын байгууллагуудтай холбоо тогтоож, харилцаа хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, хэрэгжиж байгаа хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэн хамтын ажиллагааны баримт бичгийн биелэлтийн хангаж ажиллах;

5.1.2. Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, бүс нутгийн болон олон улсын бусад байгууллагад гишүүнчлэл, төлөөллөө нэмэгдүүлэх, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр идэвхи санаачлагатай ажиллах;

5.1.3. Хоёр талт хамтын ажиллагаатай орнуудын хөгжлийн хамтын ажиллагааны донор байгууллагууд, болон бусад хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагуудын дэмжлэг, туслалцааг статистикийн техник, технологийн чадавхийг нэмэгдүүлэх, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэхэд чиглүүлэх;

5.1.4. Олон улсын болон бүсийн байгууллага, бусад улс орнуудын зохион байгуулах хурал, семинар, сургалтад мэргэжлийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор ажилтнуудыг өргөнөөр оролцуулах;

5.1.5. Бүс нутгийн болон олон улсын хэмжээний хурал, семинар, бага хурлыг өөрийн оронд зохион байгуулахад идэвх, санаачлагатай ажиллах;

5.2. *Хүлээгдэж буй үр дүн:*

- 5.2.1. Статистикийн аргачлал, арга зүйг боловсронгуй болгох, хүний нөөцийн болон мэргэжлийн, техник технологийн чадавхийг нэмэгдүүлэхэд гадаадын туслалцаа, дэмжлэг нэмэгдсэн байна;
- 5.2.2. Гадаад орнуудын статистикийн болон олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, статистикийн асуудлаарх олон улсын санаачлага, үйл ажиллагаанд Монгол Улсын гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, нэр хүнд өссөн байна;
- 5.2.3. Статистикийн салбарт хэрэгжиж буй болон хэрэгжих төсөл, хөтөлбөрийн уялдаа зохицуулалт сайжирсан байна;

Зорилт 6: Орон нутгийн статистикийн байгууллагын ажлын ачааллыг оновчтой зохион байгуулна.

6.1. *Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:*

- 6.1.1. Орон нутгийн статистикийн байгууллагын чиг үүрэг, гүйцэтгэх ажлын хүрээг оновчтой болгож, орон тоо бүтцийг ажлын ачаалалтай уялдуулах;
- 6.1.2. Судалгааны мэргэшсэн судлаачдыг тогтвор, суурьшилтай ажиллуулж, үндэсний хэмжээний тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээлэл бүрдүүлэлтийн чанарыг хангаж ажиллах;
- 6.1.3. Анхан шатны тоо мэдээллийг боловсруулах төвлөрлийг сааруулж, програм хангамж өргөн ашиглах;

6.2. *Хүлээгдэж буй үр дүн:*

- 6.2.1. Орон нутгийн статистикийн байгууллагын ачаалал жигдэрч мэдээллийн чанар, шуурхай, бодит байдал нэмэгдэнэ.

Зорилго 2. Статистикийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн статистикийн дэд бүтцийг хөгжүүлэх

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 7: Олон улсын арга зүйд нийцсэн шинжлэх ухааны үндэслэлтэй, үндэсний стандарт аргачлал, ангиллыг боловсруулан мөрдөж, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.

7.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

7.1.1. Олон улсын стандарт ангилал, аргачлалд өөрчлөлт орох, шинээр батлагдан гарах бүрт нь үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй ангилал, аргачлалд тусгаж мөрдүүлэх, нэвтрүүлэх;

7.1.2. Анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудад зориулсан стандарт ангилал, аргачлалын талаарх гарын авлагыг дэлгэрэнгүй тайлбартайгаар боловсруулж, мөрдүүлэх;

7.1.3. Арга зүйн байнгын зөвлөлийн бүтэц, чиг үүрэг, ажиллах зарчмыг оновчтой болгон шинэчилж, арга зүйн удирдлагыг хангах;

7.2. Хүлээгдэж буй үр дүн:

7.2.1. Олон улсын аргачлал, ангиллыг үндэсний хэмжээнд нэвтрүүлсэн байна.

Зорилт 8: Түүвэр судалгааны дизайныг оновчтойгоор боловсруулж, шинжлэх ухааны үндэслэлийг хангаж, нэвтрүүлнэ.

8.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

8.1.1 Түүвэр судалгааны арга зүй, үр дүнгийн бодитой байдлыг үнэлэх, тооцоолох чадавхийг бэхжүүлэх, сургах, мэргэшүүлэх;

- 8.1.2 Түүврийн дизайнуудыг статистик арга зүйтэй нь уялдуулан судалж, судалгаануудын түүврийн дизайныг боловсронгуй болгох;
- 8.1.3 Судалгааны үр дүнгийн тооцоолол хийх, жин болон орлуулалтын техникийг (imputation) ашиглах, стандарт алдааг тооцох зэрэг арга зүй, аргачлалыг судалж, нэвтрүүлэх;
- 8.1.4 Панел, ротаци, кросс секшин судалгааны дизайнуудын онцлог, ялгаатай байдал, хэрэглээг судалж, оновчтойгоор ашиглах;
- 8.1.5 Газар зүйн системд суурилсан мастер түүврийн хүрээг бий болгох;
- 8.1.6 Мастер түүврийн зохиомжийн арга зүйг судлах, ашиглах;
- 8.2. *Хүлээгдэж буй үр дүн:*
 - 8.2.1. Мастер түүврийн аргазүйг ашигласнаар мэдээллийн шуурхай, үнэн бодит байдал хангагдаж, санхүүгийн хэмнэлттэй, эдийн засгийн үр өгөөжтэй байх зарчим хэрэгжинэ.

Зорилт 9: Мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, ашиглалтыг нэмэгдүүлнэ.

- 9.1. *Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:*
 - 9.1.1. Мэдээллийн олон эх үүсвэрүүдийг уялдуулан анализ хийх, олон их үүсвэрийн “Их мэдээлэл” (Big data)-ийг ашиглах;
 - 9.1.2. Статистикийн мэдээллийн санг төрийн байгууллагуудын мэдээллийн сантай уялдуулан төрийн мэдээллийн нэгдсэн бүрдүүлж, ажиллуулах;
 - 9.1.3. Хүн ам, өрхийн мэдээллийн сан болон Статистикийн Бизнес регистрийн санг илүү боловсронгуй болгож, бусад сантай уялдуулах;

9.1.4. Статистикийн болон төрийн бүртгэл, мэдээллийн сангуудад статистикийн нэгдсэн ангилал, стандарт кодыг нэвтрүүлэх, тухай бүрт нь шинэчлэн баяжуулж мөрдүүлэх;

9.1.5. Статистикийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой олон улсын стандарт бүхий статистик нэгжийн санг байгуулах, хөтлөх;

9.2. Хүлээгдэж буй үр дүн:

9.2.1. Мэдээллийн нэг эх үүсвэртэй болж, мэдээллийн давхцалыг арилгаж, алдааг багасгах боломжтой болсон байна;

9.2.2. Байнгын үйл ажиллагаатай төрийн мэдээллийн нэгдсэн сан буюу нэг эх үүсвэрээс бүх төрлийн мэдээллийг гаргаж, бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтад ашиглана.

Зорилт 10: Шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлнэ.

10.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

10.1.1. Статистикийн шинжилгээ, судалгааны чадавхийг үнэлэх, бэхжүүлэх;

10.1.2. Их мэдээлэл (Big data)-ийг ашиглан дүн шинжилгээ боловсруулах чадавхийг бий болгох;

10.1.3. Үндэсний хөгжлийн бодлогод дэмжлэг үзүүлэх нийгэм, эдийн засгийн үзэгдлүүдийн өөрчлөлт, уялдаа холбоо, харилцан хамаарал, нөлөөллийн шинжилгээ, гүнзгийрүүлсэн, сэдэвчилсэн судалгааны ажлыг өргөжүүлэх;

10.1.4. Үндэсний тооцооны системийн тооцоолол, тэдгээрийн ашиглалтыг нэмэгдүүлэх судалгаа, шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх;

10.2. Хүлээгдэж буй үр дүн:

- 10.2.1. Улс орны хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны хандлагыг тодорхойлсон тоо мэдээллийн хэрэглээ нэмэгдэнэ;
- 10.2.2. Үндэсний болон орон нутгийн түвшинд олон жилийн динамик мэдээлэлд үндэслэн хийсэн шинжилгээ, судалгааны өгөөж нэмэгдсэн байна.

Зорилт 11: Бүтээгдэхүүн, үйлчилгээний бүх шатанд чанарын удирдлагын системийг нэвтрүүлнэ.

11.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 11.1.1 Албан ёсны статистикийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн ерөнхий загварын (Generic Statistical Business Process Model - GSBPM) нэгдсэн стандартыг боловсруулж, мөрдүүлэх;
- 11.1.2 Албан ёсны статистикийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн ерөнхий загварыг салбарын статистик бүрт боловсруулан мөрдүүлэх;
- 11.1.3 Статистикийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн дэд үе шатуудад мөрдөгдөх "Статистикийн мэдээллийн нэгдсэн загвар" (Generic Statistical Information Model - GSIM)-ыг нэвтрүүлэх талаар судлах;
- 11.1.4 Статистикийн үйл ажиллагааны бүх шатанд чанарын удирдлагын системийг нэвтрүүлэх чиг үүрэг бүхий баг/нэгжийн үйл ажиллагаа, чиг үүргийг оновчтой болгох, тогтмолжуулах, эрчимжүүлэх;
- 11.1.5 Тооллого, судалгаа болон салбарын албан ёсны мэдээлэлд чанарын нэгдсэн тайлан бичиж хэвших;
- 11.1.6 Мэдээллийн чанарын үнэлгээ, баталгаажилтын талаар дэлгэрэнгүй тайланг олон нийтэд ойлгомжтой, ил тод байдлаар тархааж хэвших;
- 11.1.7 Өөрийн үнэлгээний чанарын судалгааг томоохон тооллого, судалгааны хувьд явуулж, тайланг нэгтгэн, үр дүнг гаргах, үр дүнгийн мөрөөр холбогдох арга хэмжээг авах;

11.2. Хүлээгдэж буй үр дүн:

11.2.1. Статистикийн үйл ажиллагааны бүх шатанд чанарын удирдлага нэвтрүүлж эхэлсэн байна.

11.2.2 Статистикийн үйл ажиллагааны ерөнхий стандарт загвар бий болсон байна.

Зорилго 3. Статистикийн мэдээллийн менежментийг сайжруулах

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үндсэн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 12: Мэдээллийн эх үүсвэрүүдийн ашиглалтыг сайжруулж, шинэ эх үүсвэрийг ашиглана.

12.1 Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

12.1.1 Үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдуулан мэдээлэл, тооллого, судалгааны үзүүлэлтүүдийн хүрээг шинэчлэх;

12.1.2 Албан ёсны статистикийн болон захиргааны статистикийн мэдээллийн давхардлыг үнэлж, арилгах, холбогдох зохицуулалтыг хангах;

12.1.3 Асуулгын нэгдсэн стандартыг мөрдөх, мэдээлэл цуглуулалтанд мэдээллийн нэгдсэн сангуудаас стандарт үзүүлэлтүүдийг шууд авдаг механизмыг бүрдүүлэх;

12.1.4 Захиргааны мэдээлэл болон статистикийн зорилгоор ашиглах боломжит бүх мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлж, холбогдох журмыг боловсруулан мөрдөх;

12.2 Хүлээгдэж буй үр дүн:

12.2.1 Мэдээлэгчдийн ачаалал буурна.

12.2.2 Мэдээллийн давхардал арилж, мэдээллийн чанар сайжирна.

Зорилт 13: Тооллого, судалгааны мэдээллийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

13.1 Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 13.1.1 Сургалтын шинэ модулийг гаргаж турших, мэдээллийг цуглуулах, боловсруулах, тооцоолол, дүн шинжилгээ хийх арга зүйг сайжруулах;
- 13.1.2 Тооллого, судалгааны анхдагч мэдээллийг шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах боломжийг өргөжүүлэх;
- 13.1.3 Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогыг явуулах;
- 13.1.4 Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа явуулж, анхдагч мэдээллийн сан бүрдүүлэх, үр дүнг гарган, нийтийн хүртээл болгох, бодлого, төлөвлөлтөд ашиглах, бодлогын шинжилгээ хийх;
- 13.1.5 Ажиллах хүчний судалгаа явуулж, анхдагч мэдээллийн сан бүрдүүлэх, үр дүнг гарган, нийтийн хүртээл болгох, бодлого, төлөвлөлтөд ашиглах, бодлогын шинжилгээ хийх;
- 13.1.6 Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа явуулж, анхдагч мэдээллийн сан бүрдүүлэх, үр дүнг гарган, нийтийн хүртээл болгох, бодлого, төлөвлөлтөд ашиглах, бодлогын шинжилгээ хийх;
- 13.1.7 Цаг ашиглалтын судалгаа явуулж, анхдагч мэдээллийн сан бүрдүүлэх, үр дүнг гарган, нийтийн хүртээл болгох, бодлого, төлөвлөлтөд ашиглах, бодлогын шинжилгээ хийх;
- 13.1.8 Аж ахуйн нэгжийн ээлжит тооллогыг явуулах;
- 13.1.9 Хөдөө, аж ахуйн тооллогыг явуулж, анхдагч мэдээллийн сан бүрдүүлэх, үр дүнг гарган, нийтийн хүртээл болгох, бодлого, төлөвлөлтөд ашиглах, бодлогын шинжилгээ хийх;
- 13.1.10 Мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах;
- 13.1.11 Малын түүвэр судалгаа явуулах;
- 13.1.12 Хэрэглээний үнийн судалгаа явуулах;
- 13.1.13 Орон сууцны үнийн судалгаа явуулах;
- 13.1.14 Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа явуулах;

- 13.1.15 Барилгын салбарын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа явуулах;
 - 13.1.16 Бөөний болон жижиглэнгийн үнийн судалгаа явуулах;
 - 13.1.17 Зочид буудал, зоогийн газрын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа явуулах;
 - 13.1.18 Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа явуулах;
 - 13.1.19 Мэдээлэл, холбооны салбарын үнийн индексийн жин тогтоох, үйлдвэрлэгчийн үнийн судалгаа явуулах;
 - 13.1.20 Хөрөнгө оруулалтын судалгаа явуулах;
 - 13.1.21 Нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл байгуулах судалгаа явуулах;
 - 13.1.22 Албан бус секторын судалгаа, далд эдийн засгийн тооцоо, судалгаа явуулах;
 - 13.1.23 Бичил уурхайн судалгаа явуулах;
 - 13.1.24 Байгаль орчныг хамгаалах зардлын судалгаа явуулах;
 - 13.1.25 Тооллого, судалгааны үр дүнгээр хэрэглэгчид зориулсан гарын авлага, сурталчилгааны материал бэлтгэх;
- 13.2 Хүлээгдэж буй үр дүн:
- 13.2.1 Статистикийн тухай хуульд заасан тооллого, судалгааны анхдагч мэдээллийн сан бүрдсэн байна;
 - 13.2.2 Тооллого, судалгааны үр дүнгээр сэдэвчилсэн болон гүнзгийрүүлсэн судалгаа хийж, хэрэглэгчдийн хүртээл болгосон байна;
 - 13.2.3 Тооллого, судалгааны үр өгөөж нэмэгдэж, мэдээллийн ашиглалт сайжирсан байна;

Зорилт 14: Мэдээллийн нууцлал аюулгүй байдлын олон улсын стандартыг нэвтрүүлнэ.

14.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

14.1.1. Анхан шатны мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах нэгдсэн системийг бий болгох;

14.2. Хүлээгдэж буй үр дүн:

14.2.1. Статистикийн мэдээллийн нууцлал бүрэн хангагдсан байна.

Зорилго 4. Мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үндсэн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 15: Статистикийн үйл ажиллагааны үе шат бүрт нийцтэй, өртөг зардал багатай, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, статистикийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн ерөнхий загварыг бий болгоно.

15.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

15.1.1 Салбарын хэмжээнд сүүлийн үеийн шинэ технологийг тогтмол нэвтрүүлэх;

15.1.2 Салбарын хэмжээнд мэдээлэл боловсруулах тоног төхөөрөмжийн технологийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх /компьютер, үүлэн тооцоолох төхөөрөмж зэрэг/;

15.1.3 Мэдээлэл цуглуулахад мобайл судалгаа, их мэдээлэл /big data/, компьютерт суурилсан телефон ярилцлага /Computer-assisted telephone interviewing - CATI/) зэрэг орчин үеийн технологийг нэвтрүүлэх;

15.1.4 Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын хүрээнд e-census хийх технологийн шийдлийг судлах;

15.2 Хүлээгдэж буй үр дүн:

15.2.1 Салбарын хэмжээнд техник, технологийн шинэчлэл хийгдэж техникийн хүчин чадал сайжирсан байна.

15.2.2 Олон улсын стандартад нийцсэн мэдээлэл боловсруулах нэгдсэн системийг бий болгож, нэвтрүүлсэн байна.

Зорилт 16: Хэрэглэгчдэд мэдээллийг онлайнаар авах боломжийг бүрдүүлнэ.

16.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

16.1.1. Статистикийн мэдээллийг хэрэглэгчид онлайнар хялбар авах шуурхай, нээлттэй системийг хөгжүүлэх;

16.1.2. Статистикийн мэдээллийг засаг, захиргааны нэгж, стандарт, ангиллуудын нарийвчилсан, дэлгэрэнгүй түвшинд авах боломжийг бүрдүүлэх;

16.2. Хүлээгдэж буй үр дүн:

16.2.1. Хэрэглэгчид орон зай, цаг хугацаанаас хамаарахгүйгээр статистикийн мэдээллийг онлайнар шууд авдаг болно.

Зорилт 17: Мета мэдээллийн нэгдсэн санг бий болгож ажиллуулна.

17.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

17.1.1. Мета мэдээллийн нэгдсэн санг бий болгох

17.1.2. Олон улсын мета мэдээллийн чиг хандлагыг нарийвчлан судалж, энэ салбарт тэргүүлэгч өндөр хөгжилтэй орны туршлагаас суралцан статистикийн салбарт нэвтрүүлэх;

17.2. Хүлээгдэж буй үр дүн:

17.2.1. Статистикийн мета мэдээллийн нэгдсэн сантай болно.

Зорилт 18: Статистикийн мэдээллийн нэгдсэн санд суурилсан Нээлттэй мэдээллийн аппликэйшн / Open Data API/-ийг ашиглана.

18.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

18.1.1. Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн үзүүлэлтүүдийг цахим үйлчилгээнд шилжүүлэх;

18.2. Хүлээгдэж буй үр дүн:

18.2.1. Статистикийн мэдээллийг бусад төрлийн програм, платформд унших боломжийг бүрдүүлнэ.

Зорилго 5. Статистикийн чадавхийг бэхжүүлэх

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үндсэн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 19: Статистикийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ.

19.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

19.1.1 ҮСС-ийн албан хаагчдыг мэргэшүүлэх болон давтан сургах системчилсэн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;

19.1.2 Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн дагуу сургалтын мастер төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

19.1.3 Сум, баг, хорооны статистикийн асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан статистикийн мэдлэг, ур чадвар олгох сургалтын тусгайлсан хөтөлбөрийг боловсруулах;

19.1.4 Сургалтын тусгайлсан хөтөлбөрийн дагуу мэргэжлийн сертификат олгох сургалтыг сум, баг, хорооны ажилтнуудад тодорхой давтамжтайгаар зохион байгуулах;

19.1.5 Мэргэжлийн, дадлага туршлагатай, өндөр чадвартай боловсон хүчний нөөцийг бий болгох, тогтвор суурьшлыг хангах;

19.2 Хүлээгдэж буй үр дүн:

19.2.1 Хүний нөөцийн чадавхи бэхжиж, статистикийн бүтээмж дээшилсэн байна.

Зорилт 20: Статистикийн мэдлэг олгох ажлыг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн нэг хэсэг болгоно.

20.1 Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

20.1.1 Дунд болон ахлах сургуулийн түвшинд статистикийн суурь мэдлэг олгох хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;

20.1.2 Статистикийн байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн төв байгууллагууд хамтран дунд болон ахлах сургуулийн түвшинд зориулсан статистикийн онолын чиг баримжаа олгох стандарт сурах бичиг боловсруулах;

20.2 Хүлээгдэж буй үр дүн:

20.2.1 Олон нийтийн статистикийн суурь боловсролыг бий болгосноор статистикийн мэдээллийн ашиглалт нэмэгдсэн байна.

Зорилго 6. Статистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох

Статистикийн үйл ажиллагааны боловсронгуй болгох зорилго нь хүн ам зүйн болон нийгэм; эдийн засаг; байгаль орчин, байгалийн нөөцийн статистик; тогтвортой хөгжил; засаглалын гэсэн таван бүлэгт чиглэгдэнэ.

Зорилт 21: Хүн ам зүйн болон нийгмийн статистикийг өргөжүүлж, чанартай, үнэн бодит, найдвартай, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлнэ.

21.1 Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Одоогийн цуглуулж буй мэдээллийг сайжруулах, өргөжүүлэх

- 21.1.1 Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үр дүнг тооцоо судалгаанд ашиглах боломжийг нэмэгдүүлэх;
- 21.1.2 Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үр дүнгээр гүнзгийрүүлсэн судалгаа хийх;
- 21.1.3 Хүн ам, нийгмийн салбарын захиргааны статистикийн мэдээллийн хамрах хүрээ, чанар, захиргааны мэдээллийг албан ёсны статистикт ашиглах хэрэгцээг нэмэгдүүлэх;
- 21.1.4 Захиргааны статистикийн мэдээллийн үзүүлэлтүүдийг жендэрийн мэдрэмжтэй болгох, жендэрийн статистикийн үзүүлэлтэд үндэслэж, дүн шинжилгээ хийх;
- 21.1.5 Боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, орон сууц, хот нийтийн аж ахуйн үйлчилгээ, гэмт хэрэг, шүүх, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын статистикийн үзүүлэлтүүдийн хүрээ, маягт, зааврыг тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдтэй уялдуулан шинэчлэх;
- 21.1.6 Хөгжлийн бэрхшээлийн талаарх статистикийн мэдээллийг боловсронгуй болгох;

Аргачлал, арга зүйг боловсронгуй болгох

- 21.1.7 Хүний хөгжлийн индекс, дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн загварыг ашиглан жил бүр Монгол Улсын хөгжлийн үзүүлэлтүүдийг гаргах, тооцох арга зүйг боловсронгуй болгох;
- 21.1.8 Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмжийг судалж, нэвтрүүлэх /Хувилбар.3/;
- 21.1.9 “Хүн амын ердийн хөдөлгөөний талаарх статистикийн системийн зарчим, зөвлөмж-3”-ийг судалж, нэвтрүүлэх;
- 21.1.10 Хүн амын амьжиргаа, ядуурлын түвшинг өөрийн орны онцлогт тохирсон олон хэмжээст үзүүлэлтээр тооцох арга зүйг судалж, аргачлалыг нэвтрүүлэх;
- 21.1.11 Гэмт хэргийн олон улсын ангиллыг үндэсний онцлогт тохируулан боловсруулж, мөрдүүлэх;
- 21.1.12 Шинжлэх ухааны статистикийн, үзүүлэлт тооцох аргачлал боловсруулах;
- 21.1.13 ОУХБ-аас гаргасан аргачлал, гарын авлагыг судалж, цалин хөлсний статистикийн арга зүйг үндэсний онцлогт нийцүүлэн боловсронгуй болгох;
- 21.1.14 ОУХБ-аас тодорхойлсон Зохистой хөдөлмөрийн үзүүлэлтийг тооцох арга зүйг судалж, нэвтрүүлэх;
- 21.1.15 Амьдралын чанарын үзүүлэлтүүдийн хүрээг тогтоох, тооцох;

Зорилт 22: Эдийн засгийн салбарын статистикийг өргөжүүлж, чанартай, үнэн бодит, найдвартай, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлнэ.

Одоогийн цуглуулж буй мэдээллийг сайжруулах, өргөжүүлэх

- 22.1.1. ДНБ-ий жил, улирлын тооцоог НАХ-д үндэслэн тодотгох;
- 22.1.2. ДНБ-ий жил, улирлын тооцоо, хамралт, мэдээллийн чанарыг сайжруулж, ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоонд давхар дефляторын аргыг нэвтрүүлэх;
- 22.1.3. НАХ-ийг зэрэгцүүлэх үнээр байгуулах;

- 22.1.4. “Төлбөрийн тэнцэл-6” шинэчилсэн арга зүйн дагуу хийгдсэн тооцооллыг үндэсний тооцоонд тусгах;
- 22.1.5. Засгийн газрын санхүүгийн статистикийн шинэчилсэн арга зүйн дагуу хийгдсэн тооцооллыг үндэсний тооцоонд тусгах;
- 22.1.6. Мөнгө, санхүүгийн статистикийн шинэчилсэн арга зүйг үндэсний тооцоонд тусгах;
- 22.1.7. Үндэсний тооцооны дансыг иж бүрнээр нь байгуулах;
- 22.1.8. Үнийн суурь шинэчлэх судалгааг явуулах, индексийн тооцооллыг хийх;
- 22.1.9. Хөрөнгө болон хөрөнгийн үйлчилгээний статистикийн мэдээллийг бий болгох;
- 22.1.10. Далд эдийн засгийг НАХ-д тусгах;
- 22.1.11. Малын ашиг шимийн бүтээгдэхүүний мэдээллийг цуглуулж, нэмэгдэл өртгийн тооцоонд ашиглах норм, нормативыг шинэчлэн тооцох;
- 22.1.12. Үйлдвэрлэлийн индекс тооцох;
- 22.1.13. Нийгмийн тооцооны матрицыг байгуулах;
- 22.1.14. Аж ахуйн нэгжийн ээлжит тооллогын үр дүнгээр аж ахуйн нэгж байгууллагын шинж төлвийн талаар сэдэвчилсэн судалгаа хийж нийтийн хүртээл болгох;
- 22.1.15. Хөдөө, аж ахуйн завсрын тооллогын үр дүнгээр сэдэвчилсэн судалгаа хийж нийтийн хүртээл болгох;

Аргачлал, арга зүйг хөгжүүлэх

- 22.1.16. Хөрөнгийн үйлчилгээний гарын авлага боловсруулах (perpetual inventory method - PIM аргыг нэвтрүүлэх);
- 22.1.17. Үйлчилгээний салбарт үйлдвэрлэгчийн үнийн индекс тооцох арга зүйг боловсронгуй болгох, салбаруудаар өргөтгөх;
- 22.1.18. Үйлдвэрлэгчийн үнийн индексийг тооцох судалгааг явуулж, мэдээллийг бий болгох, тооцооллыг хийх;

- 22.1.19. Эдийн засаг дахь уул уурхай, олборлох салбарын нөлөөллийг тооцох гарын авлагыг боловсруулах, холбогдох шинжилгээ, судалгааг хийх;
- 22.1.20. Нийгмийн тооцооны матрицыг байгуулах аргачлалыг боловсруулах;
- 22.1.21. Харилцаа холбооны салбарын үйлчилгээний үнийн индекс тооцох аргачлал боловсруулах;
- 22.1.22. Аж үйлдвэрийн салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал боловсруулах;
- 22.1.23. Бүтээмж тооцох аргачлал боловсруулах;
- 22.1.24. Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлалыг шинэчлэх;
- 22.1.25. ДНБ-ийг тооцох аргачлалд өөрчлөлт оруулах, шинэчлэх;
- 22.1.26. Бүс нутгийн ДНБ-ийг тооцох аргачлал боловсруулах;
- 22.1.27. Бүс нутгийн үндсэн хөрөнгийн хуримтлалыг тооцох аргачлал боловсруулах;

Зорилт 23: Байгаль орчин, эдийн засгийн нэгдсэн дансны дэд дансуудыг байгуулж, байгаль орчин, байгалийн нөөцийн статистик мэдээллийг өргөжүүлнэ.

Одоогийн цуглуулж буй мэдээллийг сайжруулах, өргөжүүлэх

- 23.1.1 БОЭЗДС-ийн хүрээний материалын урсгалын данс, эрчим хүчний данс, татварын данс, байгаль орчин хамгаалах зардлын данс болон хөдөө аж ахуйн данс байгуулахтай холбогдуулан үзүүлэлтүүдэд үнэлгээ хийх, шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, холбогдох тооцооллыг хийж, дэд дансыг байгуулах, цаашид боловсронгуй болгох;

Аргачлал, арга зүйг хөгжүүлэх хүрээнд:

- 23.1.2 БОЭЗДС-ийн хүрээний дэд дансыг байгуулах гарын авлага, үндэсний аргачлалыг боловсруулах;

Зорилт 24: Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг бий болгоно.

Одоогийн цуглуулж буй мэдээллийг сайжруулах, өргөжүүлэх

- 24.1.1 Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үндэсний шалгуур үзүүлэлтүүдийг бий болгох, хянах, хэрэгжилтийг хангах институцийн бүтцийг холбогдох байгууллагуудтай хамтран бүрдүүлэх;
- 24.1.2 Тогтвортой хөгжлийн үндэсний болон дэлхийн үзүүлэлтүүдийг урт хугацааны хөгжлийн бодлогын болон салбаруудын стратегийн бодлогын хөтөлбөрүүдтэй уялдуулахад хамтран ажиллах;
- 24.1.3 Тогтвортой хөгжлийн үндэсний болон дэлхийн шалгуур үзүүлэлтүүдийн талаар суурь болон тайлант оны мэдээллийг гаргах;
- 24.1.4 Тогтвортой хөгжлийн зорилтын талаар олон улсын туршлага судлах, сургалт, семинарт хамрагдах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа хийх;
- 24.1.5 Ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлж, тооцооллыг хийх;

Аргачлал, арга зүйг хөгжүүлэх хүрээнд:

- 24.1.6 Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийн хүрээг тодорхойлж, аргазүйг боловсруулж, мөрдөх;
- 24.1.7 Ногоон хөгжлийн үзүүлэлтүүдийн хүрээг тодорхойлж, арга зүйг боловсруулж, мөрдөх;

Зорилт 25: Засаглалын статистикийг бий болгож, хөгжүүлнэ.

Засаглал, хүний эрх

- 25.1.1 Салбар бүрийн хамрах хүрээнд бодлого боловсруулах, шийдвэр гаргах, явцыг үнэлэхэд хэрэгцээтэй, ач холбогдолтой байх статистикийн үзүүлэлтийг тодорхойлох;
- 25.1.2 Стандарт ойлголт, ангиллыг боловсруулж, мөрдөх;

Хуулийн хэрэгжилт, авилга

- 25.1.3 Стандарт ойлголт, ангиллыг боловсруулж, мөрдөх;

25.1.4 Мэдээллийг нэгтгэх, мэдээллийн менежмент, дүн шинжилгээ хийх, тайлбарлах чиглэлээр статистикийн ур чадварыг хөгжүүлэх;

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

- 5.1 Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, статистикийн салбарын хөгжүүлэх төсөл, хандивлагч орон, хамтран ажилладаг байгууллагын дэмжлэг, туслалцаа бусад эх үүсвэрээс бүрдэнэ.
- 5.2 Хөтөлбөрийг 46.3 тэрбум төгрөгийн хөрөнгөд багтаан хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийт зардлын тооцоо

Зорилго	Нийт дүн, сая төгрөгөөр
1. Бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх	1 764.6
2. Статистикийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлэх	2 112.5
3. Статистикийн мэдээллийн менежментийг сайжруулах	30 825.6
4. Мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	5 705.3
5. Статистикийн чадавхийг бэхжүүлэх	984.6
6. Статистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох	4 414.5
7. Болзошгүй ажлын зардал	500.0
Нийт дүн	46 307.1

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАХ ТОГТОЛЦОО

- 6.1 Хөтөлбөрийн стратегийн зорилт, салбарын зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг статистикийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд дэлгэрэнгүй байдлаар тусгаж хэрэгжүүлнэ.
- 6.2 ҮСХ-ноос хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүр хийх бөгөөд нэгдсэн хяналт, шинжилгээ, үнэлгээг хоёр үе шаттай хийнэ. Үүнд:

Нэгдүгээр үе шат: 2018 оны 6 дугаар сар

Хоёрдугаар үе шат: 2020 оны 6 дугаар сар

- 6.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг статистикийн асуудал хариуцсан төв байгууллагаас яамд, төрийн бусад байгууллагатай хамтран хийж, гүйцэтгэнэ.
- 6.4 Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хийх, удирдах, зохицуулах ажлыг нийслэл, аймгийн ИТХ-ын дарга болон засаг дарга, статистикийн газар, хэлтэстэй хамтран гүйцэтгэнэ.
- 6.5 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын үнэлгээний үр дүнг үндэсний статистикийн зөвлөлд танилцуулж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийг дууссаны дараа нэгдсэн дүнг УИХ-ын холбогдох байнгын хороонд танилцуулна.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН

- 7.1 ҮСС-ийн зохицуулалт, хөгжлийн бодлогыг удирдан ажиллах ҮСХ-ны зохион байгуулалт, удирдлага, хүний нөөцийн болон оролцогч талуудын чадавхи сайжирна.
- 7.2 Статистикийн дэд бүтцийн хүрээнд түүврийн хүрээ, статистикийн арга зүй, аргачлал, статистикийн стандарт, хууль эрхзүйн зохицуулалт хангагдсан байна.
- 7.3 ҮСС-ийн байгууллага, нэгжүүдийн гаргасан салбарын мэдээлэл, хөгжлийн бодлоготой уялдсан, хамралт, нарийвчлал, хүртээмж, чанар сайжирна.
- 7.4 Түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах илүү үр дүнтэй системийг нэвтрүүлсэн байна.
- 7.5 Чиг үүргийн яамдын статистикийн чадавхи сайжирч, мэдээллийн сан, ажиллагчдын дүн шинжилгээний чадварыг сайжруулснаар эдийн засгийн болон ядуурал, байгаль орны статистикийн дүн шинжилгээний ажил өргөжиж, илүү нарийвчилсан мэдээллээр хангагдана.

- 7.6 Холбоо харилцааны болон мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлснээр статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, тархаах, хадгалах бүхий л үйл явц сайжирна.
- 7.7 Хэрэглэгчдийн статистикийн боловсрол сайжирна.
- 7.8 Статистикийн гадаад хамтын ажиллагаа өргөжиж, олон улсын хүрээнд статистикийн нэр хүнд өснө.

—oOo—